





МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2012 ОНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГО

Манай улсын эдийн засгийн бодит өсөлт өнгөрсөн онд 12.3 хувьтай гарсан хэдий ч, улсын төсвийн алдагдал 1.1 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 7.7 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч өссөний дотор нийгмийн хавтгайрсан халамжид 1 их наяд төгрөгийг зарцуулжээ. Нийт мөнгөний нийлүүлэлтийн 65 хувийг төгрөгийн ба гадаад валютын хадгаламж эзэлдэг ч, банкны системийн хадгаламжийн дундаж хугацаа ердөө 3 сар, нийт зээлийн 17 хувийг иргэдийн хэрэглээний зээл эзэлж, энэхүү хувь хэмжээ нь өнгөрсөн 3 жилд 3 дахин өссөн байна. Ийм нөхцөлд халамжийн зардлыг 2012 оны эхний хагаст огцом нэмэгдүүлж, хэрэглээг ирээдүйн экспортын орлогыг барьцаалсан гадаад худалдааны зээлээр голчлон санхүүжүүлсэн нь макро эдийн засгийн эрсдлийг нэмэгдүүлж, нийт эдийн засагт сөргөөр нөлөөлөв.

2012 онд гадаад худалдааны нөхцөл 18 хувиар муудсан нь экспортын орлого 9 хувиар буурах, импорт 2 хувиар өсөхөд нөлөөлж, улмаар гадаад худалдааны алдагдал 2.3 тэрбум ам.долларт хүрч 40 хувиар өсөх, макро эдийн засгийн суурь үзүүлэлт болох урсгал тэнцлийн алдагдал 3.3 тэрбум ам.доллар болж, дотоодын нийт бүтээгдэхүүний 32 хувьтай тэнцэх хэмжээнд хүрэхэд нөлөөлөв. Гэтэл урсгал тэнцэл, гадаад худалдааны алдагдлыг санхүүжүүлж байсан эх үүсвэр болох хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалт 800 орчим сая ам.доллараар буюу 17 хувиар огцом буурсан нь төлбөрийн тэнцэл, валютын хямралын эрсдлийг өдөөж, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдалд ч сөргөөр нөлөөлж болзошгүй байсан юм. Үүнтэй уялдан эдийн засаг дахь нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч, эдийн засгийн идэвхжил удааширсны зэрэгцээ бодит эдийн засгийн өсөлт сүүлийн 6 улирал дараалан буурлаа.



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Гадаад секторын эрсдэл эрс өссөн, макро эдийн засгийн орчин муудсан, эдийн засгийн бодит өсөлт удааширсан үед Монголбанк болзошгүй хямралаас урьдчилан сэргийлсэн, эдийн засгийн мөчлөгийг сөрсөн, санхүүгийн болон макро тогтвортой байдлыг хангасан бодлого хэрэгжүүлж, Засгийн газартай хамтран шаардлагатай арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлсний үр дүнд 2013 оны макро эдийн засгийн харьцангуй тогтвортой суурийг бүрдүүлээд байна.

Макро тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлж, дундаж давхаргыг дэмжих, бодит эдийн засгийн удаашрал, уналтыг сөрсөн, эдийн засгийн идэвхжилийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхийн тулд инфляцийг нэн даруй бууруулж, нам түвшинд нь тогтвортой байлгах шаардлагатай. Инфляцийг зорилтот түвшинд нь хүртэл бууруулах, улмаар тогтвортой байлгах зорилтын хүрээнд зах зээл дэх гажуудлыг арилгах, нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулах зорилготой “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд инфляци сүүлийн 6 сарын хугацаанд 5.2 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 6.4 нэгж хувиар буураад байна. Өнгөрсөн оны эхний улиралд инфляци 7.5 хувьд хүрч огцом өсөөд байсан бол энэ оны мөн үед 3.6 хувь болж 2.1 дахин буурчээ. Жилийн инфляци 2012 оны эцэст 14.0 хувь байсан бол гурван сарын дотор 9.8 хувь болж нэг оронтой тоонд орлоо. Мөн суурь инфляцид ч буурах хандлага гарч, 2013 оны 2 дугаар сард 8.7 хувь болсон байна.

Инфляцийг ийнхүү бууруулсан, эрэлтийн болон нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт багассан, инфляцийн хандлага зорилтот түвшинтэй нийцтэй байсан нь мөнгөний бодлого, түүний арга хэрэгслээр бодит эдийн засгийн идэвхжилийг дэмжих боломжийг бүрдүүлээ. Иймд, Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл оны эхнээс бодлогын хүүг 2 удаа, нийтдээ 1.75 нэгж хувиар бууруулан 11.5 хувьд хүргээд байна. Мөн хүүний корридор нэвтрүүлж, банк хоорондын захын дундаж хүүг мөнгөний бодлогын хүүний ойролцоо хэлбэлзэх, банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, улмаар эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлөх нөхцлийг бий болгов. Ингэснээр банкуудын Монголбанкнаас авах санхүүжилтийн хүү 17.5 хувиас 12.0 хувь болж буурсан бөгөөд энэ нь цаашид зээлийн хүүг бууруулахад ч эерэгээр нөлөөлөх юм.

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан, эдийн засагт орж ирсэн валютын хэмжээ цэвэр дүнгээр 48 хувиар буурсан үед Засгийн газраас олон улсын зах зээлд үнэт цаас арилжаалан эх үүсвэр бүрдүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэв. Энэ нь 2012 онд төлбөрийн тэнцэл, валютын ханшийн хямралын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чухлаар нөлөөлсөн юм.

Монголбанк Засгийн газартай байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-ний хүрээнд зээл өсдөг улирлыг угтан банкуудад 850 тэрбум төгрөгийг 7 хувийн хүүтэй, 12 сарын хугацаагаар байршуулаад байна. “Санхүүгийн зуучлалын гэрээ” болон “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд нийтдээ 1.1 их наяд төгрөгийг эдийн засагт нийлүүлж, эдийн засгийн удаашралын мөчлөгийг сөрсөн, бодит секторыг дэмжсэн, зээл, хөрөнгө оруулалтыг урамшуулахад чиглэсэн, илүү урагш харсан, эрсдлээс урьдчилан сэргийлсэн бодлогыг хэрэгжүүлж байна.

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2012 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН 58 ДУГААР ТОГТООЛЫН
ХЭРЭГЖИЛТ (2012 ОН)**

2. Эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөл болсон макро зохистой бодлогын арга хэрэгслийг тодорхойлж, харилцан уялдаатай хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

Монголбанк ОУВС-гаас олон улсын хэмжээнд явуулсан судалгааны үр дүн, нийтэд түгээсэн судалгааны үр дүн зэргийг үндэслэн макро зохистой хэрэгслүүдийг боловсруулж, Захирлуудын зөвлөлөөрөө хэлэлцүүлсний үндсэн дээр макро зохистой хэрэгслүүдийг сонгон холбогдох арга хэмжээг шаардлагатай үед нь авч ажилласан. Тухайлбал, заавал байлгах нөөцийн хувийг 1 хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэж, 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх зохистой харьцааны доод хэмжээг 25 хувь, өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцааг 7 хувиар мөрдүүлж эхэлсэн. Эдгээр арга хэмжээ нь системийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн 2012 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс байнгын үйл ажиллагаатай ажлын алба байгуулахаар шийдвэрлэж тус албатай холбогдох дүрэм журам, шийдвэрийн төслийг боловсруулсан болно. Ажлын алба нь Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны харилцан уялдаатай макро зохистой бодлого хэрэгжүүлэх тогтвортой харилцааг бүрдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлын хэрэгслүүдийг судлах, шаардлагатай тохиолдолд бодлогын санал оруулж байх, санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам гаргах үүргийг хүлээнэ.

Макро эдийн засгийн бодлого зохистой байх гол үндэс нь төсвийн мөчлөг сөрсөн бодлогыг бусад макро бодлогын хамт цогцоор нь хэрэгжүүлж, урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийн гол суурь болгох явдал билээ. Төсвийн бодлого мөчлөг дагаж, төсвийн алдагдал өндөр байсан нь макро эдийн засгийн бодлого үр ашигтай байх нөхцлийг бүрдүүлэхгүй байгаа болон төсөв, мөнгөний бодлого харилцан уялдааг хангах талаар санал боловсруулан Засгийн газарт удаа дараа хүргүүлсэн.

Олон улсын валютын сангийн төлөөлөгчид 2012 оны 1 дүгээр сарын 17-ноос 25-ны өдрүүдэд Монголбанкинд ирж ажилласан бөгөөд мөчлөг сөрсөн бодлого, макро зохистой институциуд болон макро зохистой бодлого, түүний хэрэгжилт зэрэг сэдвээр олон нийтэд болон Монголбанкинд танилцуулга хийсэн. Мөн Монголбанкны Захирлуудын зөвлөлд Макро зохистой бодлого, хэрэгслүүд, динамик эрсдлийн сангийн талаарх танилцуулгыг бэлтгэж, өнөөгийн нөхцөлд ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар хэлэлцүүлэг өрнүүлэн тодорхой зөвлөмжийг өгсөн. Монголбанкнаас 2011 онд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг нэмэгдүүлэн тогтоосноос гадна банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан.


**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР
2012 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ
(2012 оны эцсийн байдлаар)**

Нэг. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2012 онд нэг оронтой тоонд, 2013-2014 онуудад найман хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгах.

2012 оны жилийн инфляци улсын хэмжээнд 14 хувьтай гарсан нь өмнөх оноос 3.8 нэгж хувиар өсчээ. Жилийн инфляци оны эхний 4 сард 10.2 хувиас 16 хувь хүртэл хурдацтай өсөөд байсан ч аажмаар буурч, харьцангуй тогтворжсон бөгөөд 12 дугаар сарын жилийн инфляцийн түвшин инфляцийн зорилтот түвшнээс 4.1 хувиар өндөр гарсан байна. Сарын инфляци улсын хэмжээнд оны эцэст өмнөх сараас 0.6 нэгж хувь өндөр буюу 0.8 хувь гарсан (Зураг 1.1.1)

Зураг 1.1.1: Жилийн инфляци (улсын хэмжээнд)



Эх сурвалж: Монголбанкны сарын бюллетень, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

Улаанбаатар хотын жилийн инфляци 2012 онд 14.2 хувьд хүрсэн нь өмнөх оноос 4.8 нэгж хувиар өссөн дүн юм. Махны үнийн огцом өсөлтөөс шалтгаалан оны эхний 4 сард жилийн инфляци 10.9 нэгж хувиас 17.8 нэгж хувь хүртэл өссөн (Зураг 1.1.2). 4 дүгээр сараас хойш 0.2 хувиас 1.4 хувийн хооронд хэлбэлзэж байсан сарын инфляци 11 дүгээр сард хатуу түлшний үнийн бууралттай холбоотойгоор буурч, 12 дугаар сард 0.7 хувьд хүрсэн байна.

Зураг 1.1.2: Жилийн инфляци (Улаанбаатар хотын хэмжээнд)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2012 оны Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр нь задлан үзвэл мах, махан бүтээгдэхүүн 4.8 нэгж хувь, махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн 1.1 нэгж хувь, шатахуун 0.3 нэгж хувь, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ 1.2 нэгж хувь, бусад бараа, үйлчилгээ 6.9 нэгж хувийг тус тус эзэлж байна.

Монголбанк үнийн өсөлтийг сааруулах, цаашид мөнгөний нийлүүлэлтээр инфляцийг тэтгэхгүй байх, Хүний хөгжил сангаас олгосон бэлэн мөнгө зэрэг эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгаж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор 2012 оны 1 дүгээр улиралд мөнгөний бодлогыг чангаруулж, бодлогын хүүг 0.5 нэгж хувиар 2 удаа өсгөн 13.25 хувьд хүргэж, арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 1 нэгж хувиар нэмэгдүүлэн 12 хувьд хүргэсэн. Эдгээр бодлогын арга хэмжээ болон макро эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан инфляци өсөх дарамт багасч, инфляцийн түвшин 4 дүгээр улиралд 1 дүгээр улирлаас 3.1 нэгж хувиар буурсан байна. 2012 оны 2, 3, 4 дүгээр улиралд гадаад болон дотоод эдийн засгийн төлөв байдал, тодорхой бус байдлаас шалтгаалан мөнгөний бодлогод өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

Монголбанк 2012 онд нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг бууруулах зорилгоор Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг баталж, 2012 оны 10 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөрт “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах”, “Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний өртөгийг бууруулах”, “Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах”, “Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах” гэсэн дөрвөн дэд хөтөлбөр багтаж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2012 онд нийт 194 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сайжруулах, инфляцийн дарамтыг бууруулах, улмаар үнийг тогтворжуулахад эерэгээр нөлөөллөө.

Хүснэгт 1.1.1: Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн үндсэн үзүүлэлт
(хугацааны эцэст, өөрөөр заагаагүй бол өөрчлөлтийн хувь)

Үзүүлэлт	ХП.2010	ХП.2011	ХП.2012	ХП.2012
				ХП.2011
Инфляци (жилийн өөрчлөлт)				
УБ хотын	14.3	9.4	14.2	51.1%
Мөнгөний нийлүүлэлт (тэрбум төгрөг)	4,680.0	6,412.3	7,617.3	18.8%
M1 мөнгө	1,157.6	1,741.1	1,835.4	5.4%
Бараг мөнгө	3,522.4	4,671.2	5,781.9	23.8%
Нөөц мөнгө	945.5	1,659.8	2,166.2	30.5%
Зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж)				
Төгрөгийн зээлийн нэрлэсэн хүү	17.9	15.5	14.9	
Валютын зээлийн нэрлэсэн хүү	12.6	12.1	12.2	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк сарын мэдээ

Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтыг сайжруулах хүрээнд: Ирээдүйг харсан мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад гурван төрлийн загвар ашиглаж, тэдгээрийн үр дүнг нэгтгэн ашиглаж байна. Эдгээр загваруудын таамаглах чадварыг дээшлүүлэх зорилгоор загваруудын үнэлгээнд сүүлийн үеийн тоон шинжилгээний аргыг нэвтрүүлсэн. Тухайлбал, инфляцийн түвшинг дээрх 3 загварын дундаж таамаглалын тодорхой бус байдлыг илтгэсэн график хэлбэрээр мэдээлж, SVAR загварын үнэлгээг Бейсийн аргаар хийж байгаа бөгөөд түүврийн гаднах алдааг хамгийн бага байлгахуйц таамаглал, симуляци шинжилгээг хийсэн. Үүний зэрэгцээ Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)-ны техник туслалцаагаар “Таамаглал, бодлогын шинжилгээний систем (FPAS)”-ийг хөгжүүлэх ажлыг эхлүүлж, эхний шатны сургалтыг зохион байгуулан инфляцийн төсөөлөл хийх SVAR загварыг сайжрууллаа.

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтох зарчмыг баримтална.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь гадаад худалдааны нөхцөл, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төсвийн тэлэлт, хувийн хэвшлийн хэрэглээ, хөрөнгө оруулалтын үйл хөдлөл, эдийн засгийн бусад суурь нөхцлүүдтэй нийцтэйгээр уян хатан тогтож байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2012 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар 1,392.1 төгрөгт хүрсэн нь тухайн оны эхнээс 0.3%-иар буюу 4.3 төгрөгөөр чангарчээ. Харин оны туршид авч үзвэл, төгрөгийн ам.доллартай харьцах ханш нь шатахууны үнийн огцом өсөлтөөс шалтгаалан 2012 оны 1 дүгээр сарын эхэнд 2.6%-иар буюу 3.2 төгрөгөөр суларсан хэдий ч, макро эдийн засгийн суурь нөхцлийг даган 4 дүгээр сар хүртэл эргээд 9.3%-иар буюу 132.9 төгрөгөөр чангарч, сүүлийн 8 сарын хугацаанд буцаад 7%-иар буюу 91.4 төгрөгөөр аажим суларчээ.

Зураг 1.2.1: Валютын цэвэр урсгал ба төгрөгийн ам.доллартай харьцах ханш




Эх сурвалж: Монголбанк

Тайлант хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 1.0%-иар чангарч, 0.8%-иар суларч, нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.14% байсан нь төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл маш бага байсныг илэрхийлж байна.

Зураг 1.2.2-оос үзэхэд 2012 онд нийт өдрийн 50%-д нь төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн нэг өдрийн дундаж хэлбэлзэл 0.10%-иас бага байсан нь төгрөгийн ам.доллартай харьцах ханш бүтэн жилийн хугацаанд чангарах болон сулрах чиглэлд өөрчлөгдсөн ч, хэлбэлзэл нь маш тогтвортой байсныг харуулж байна.

Зураг 1.2.2: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл



Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хөдөлгөөнд 2012 оны эхний хагаст гадаадын шууд хөрөнгө оруулалт 21%-иар буурсан нь голлон нөлөөлж байсан бол оны сүүлийн хагас дахь ханшийн хөдөлгөөнийг гадаад худалдааны нөхцөл 23%-иар муудсан, экспортын орлогын бууралт, нэгдсэн төсвийн урсгал зардлын 45%-ийн өсөлтөөс үүдэлтэй хувийн хэвшлийн хэрэглээний өсөлт, хөрөнгө оруулалтын зардал тайлбарлаж байна.

Дээрх нөхцөл байдлын нөлөөгөөр гадаад валютын орох урсгал 3.9%-иар, гарах урсгал 8.7%-иар тус тус өссөнөөр валютын урсгалын нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 2.2%-иар өсчээ. Гадаад валютын гарах урсгал нь орох урсгалаас илүү хурдацтай өссөнөөр валютын цэвэр урсгал 2011 онд 817.4 сая ам.доллартай тэнцэх хэмжээтэй байсан бол 2012 онд 429.2 сая ам.доллар болж, 388.2 сая ам.доллараар буюу 47.5%-иар буурсан байна.

Монголбанк төгрөгийн валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр валютын захын үйл ажиллагаанд шаардлагатай үед оролцон зохицуулалт хийж байна. Тухайлбал, валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны, түр зуурын шинжтэй зөрүүг багасгах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, захад оролцогчдын хүлээлтийг тогтворжуулах зорилгоор тайлант хугацаанд 105 удаагийн валютын дуудлага худалдаагаар нийт 1,017.6 сая ам.доллар худалдаж, 377.7 сая ам.доллар худалдан авсан бөгөөд цэвэр дүнгээр 639.9 сая ам.долларыг валютын захад нийлүүлсэн байна. Мөн юанийн дуудлага худалдаагаар нийт 2,522.9 сая юанийг захад нийлүүлэв.

Монголбанк шаардлагатай үед юанийн спот захад оролцох нөхцлийг бүрдүүлэн ажилласны зэрэгцээ төгрөг-ам.долларын болон төгрөг-юанийн своп, форвард хэлцлүүдийг банкуудтай хийж байгаа нь валютын захын тогтвортой байдлыг хангах, банкуудын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, спот захад үзүүлэх дарамт, ачааллыг бууруулах, ханшийн зөв хүлээлтийг төлөвшүүлэх, захад оролцогчдыг валютын ханшийн эрсдэлээ удирдахад нь дэмжлэг үзүүлэх зэрэг ач холбогдолтой болж байна.

1.3. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилгоор Засгийн газар болон холбогдох бусад байгууллагатай хамтран санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх макро зохистой бодлогын тогтолцоог бүрдүүлнэ.

Макро зохистой бодлогын тогтолцоог сайжруулах чиглэлээр Монголбанкнаас ОУВС-гийн Ази номхон далайн орнуудын бүс нутгийн уулзалтад оролцож, бүс нутгийн орнуудад макро зохистой бодлогыг хэрхэн хэрэгжүүлж буй талаар туршлага солилцон, макро зохистой бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг судалсан.

Монголбанк 2012 онд өөрийн оронд хэрэгжүүлж болох макро зохистой хэрэгслүүдийг боловсруулах, тохиромжтой хэрэгслүүдийг сонгох, холбогдох арга хэмжээг шаардлагатай тухай бүр авах чиглэлээр ажиллалаа. Тухайлбал, банкуудын заавал байлгах нөөцийн хувийг 1 хувиар нэмэгдүүлэх, 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх зохистой харьцааны доод хэмжээг 25 хувь, өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцааг 7 хувиар тогтоох зэрэг арга хэмжээг дурдаж болно. Эдгээр арга хэмжээ нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой болсон.

Түүнчлэн мөчлөг сөрсөн макро зохистой бодлогыг нэвтрүүлэх хүрээнд банкны системийн хувьд динамик эрсдлийн санг байгуулах тооцоо хийж, динамик эрсдлийн санг амжилттай хэрэгжүүлсэн улс орнуудын туршлагыг судлан, Монголд хэрэгжүүлэх талаар санал боловсруулав. Макро эдийн засгийн бодлого зохистой байх гол үндэс болсон төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах зорилгоор төсвийн бодлогын төлвийг тооцох судалгааны

ажлыг хийж, мөнгөний бодлогын тооцоо, судалгаанд ашиглаж байна. Төсвийн бодлого мөчлөг дагасан буюу төсвийн алдагдал өндөр байсан үед макро эдийн засгийн бодлогыг үр дүнтэй байлгах нөхцлийг бүрдүүлэх, төсвийн болон мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах талаар санал боловсруулан Засгийн газарт удаа дараа хүргүүлсэн.

Хоёр. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд

2.1. Эдийн засаг, санхүүгийн салбарын түргэн өсөлт, бизнесийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн банкуудын чадавхийг дээшлүүлнэ. Банкны салбарын тогтвортой байдлыг дэмжих хяналт шалгалтын олон улсын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлэх арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хийх хяналт шалгалтын шинээр боловсруулсан олон улсын стандарт, зарчмуудаас бодлогын хувьд цаг үе нь таарч байгаа, хэрэгжүүлэх боломжтой арга хэрэгслүүдийг нэвтрүүлж эхлээд байна. Энэ хүрээнд банкны салбарын нөлөө бүхий банкуудыг тодорхойлон, нэмэлт шаардлага хэлбэрээр өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагыг тогтоосон хуваарийн дагуу 2 хувь хүртэл шат дараатайгаар нэмэгдүүлэхээр тогтсон бөгөөд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг нэмэгдүүлэн тогтоон мөрдүүлж байна.

Монголбанкнаас 2012 онд давхардсан тоогоор нийтдээ 17 удаагийн газар дээрх иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг банкуудад хийж, активын чанар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, удирдлагын чадвар, ашигт ажиллагаа, зах зээлийн эрсдэл болон төлбөрийн чадварын байдлыг шалган, зарим банкуудад өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавьсан. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөрийн чадварын үзүүлэлтийг сайжруулах зорилгоор 3 банкинд хяналт шалгалтын дунд хугацааны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, 2012 оны 12 дугаар сард дуусгавар болгоод байна.

Зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой тулгамдаж байгаа эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Банкуудын хуульчдын холбоотой хамтран нэр бүхий 8 хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулга хийх шаардлагатай болохыг судалж тогтоон, эхний шатны төслийг боловсруулсан. Уг төслийг Банкуудын холбоо болон Банк бус санхүүгийн байгууллагын холбооны хуульчдад танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд үүний үр дүнд гарсан саналд үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн А-155 тоот тушаалаар “Зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн орчинг сайжруулах” ажлын хэсгийг байгуулж, хуулийн төслийг шинэчлэн боловсруулан, УИХ-д өргөн барихаар Засгийн газарт хүргүүлээд байна.

Монголбанкнаас бичил санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг үргэлжлүүлэн хийснээр 2012 оны байдлаар нийтдээ 14 банкнаас гадна 97 бичил санхүүгийн байгууллага буюу 74 банк бус санхүүгийн байгууллага, 20 хадгаламж зээлийн хоршоо, 3 санхүүгийн түрээсийн компанитай мэдээлэл солилцож байна. Дээрх бичил санхүүгийн байгууллагуудтай мэдээлэл солилцсоноор нийт бичил санхүүгийн байгууллагын зээлийн багцын 93.1 хувийг Зээлийн мэдээллийн санд хамруулаад байна.

Түүнчлэн Татварын ерөнхий газар болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сантай өр төлбөрийн мэдээллийг онлайн горимд солилцох техникийн нөхцлийг бүрдүүлж, зээлийн мэдээллийн сангийн програмд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг хийж гүйцэтгэн, харилцан мэдээлэл солилцох гэрээ байгуулав.

Зээлийн мэдээллийн тухай хууль батлагдсантай холбогдуулан зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн секторт шилжүүлэх бэлтгэлийг хангах зорилгоор хуулийн дагуу эрх зүйн

зохицуулалтыг тодорхой болгох үүднээс Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-197 тоот тушаалаар “Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ыг боловсруулж батлуулсан.

Санхүүгийн зах зээл өргөжиж тэлэхийн хэрээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ санхүүгийн хэрэгсэл олноор бий болж байгаатай уялдан банкны бүртгэлийн үйл ажиллагааг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд дотоод, гадаадын зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, банкуудын мөрдөж буй “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг шинэчлэн, анхан шатны төслийг боловсрууллаа.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлд тусгасан инфляцийг дунд хугацаанд нам, тогтвортой түвшинд байлгах үндсэн зорилтыг хангахын тулд Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийг санхүүжүүлэх, банкуудын өөрийн хөрөнгийг дэмжих зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/176 дугаар тушаалаар “Банкны өөрийн хөрөнгөд дэмжлэг үзүүлэх түр журам”-ыг баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэн, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

2.2. Банкны удирдлагыг сайжруулан үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлж, шударга өрсөлдөөнийг дэмжин, санхүүгийн хариуцлагыг өндөржүүлнэ.

Банкуудын ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн тайлан болон хувь нийлүүлэгчид, тэдгээртэй холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод байлгахыг хуулиар үүрэг болгож, банкуудын цахим хуудаст тогтмол мэдээлж байхаар зохицуулаад байна.

Банкны зохистой засаглалын шилдэг туршлагыг нэвтрүүлэх, удирдлагын ил тод байдлыг хангах үүднээс “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын биелэлтийг жилд 2 удаа тогтмол үнэлэхээс гадна газар дээрх иж бүрэн шалгалтаар удирдлага зохион байгуулалт, мэдээллийн технологийн эрсдлийн удирдлагын шалгалтыг хийж, үнэлгээ өгч байна.

2.3. Хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангана.

“Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуулийн үйлчлэх хугацаа 2012 оны 11 дүгээр сард дууссантай холбоотойгоор хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэхээр Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох байгууллагуудын төлөөлөлтэй ажлын хэсгийг байгуулж, “Хадгаламжийн даатгалын тухай” хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газраас УИХ-д өргөн барьсан. 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр тус хуулийг УИХ-аар батлуулав.

Тус хуулийг батлуулснаар санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, харилцагчдын хөрөнгийг хамгаалж, банкны салбарын эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдэж байгаа бөгөөд энэ ажлын хүрээнд банкууд дахь хадгаламжийн холбогдох судалгааг улирал бүр хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон.

Мөн “Мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай” хуульд заасны дагуу банкуудаас цуглуулах шимтгэлийн хэмжээг тогтоох, төвлөрүүлэх ажлыг эхлүүлэхтэй холбоотойгоор Сангийн яамтай хамтран Банкуудаас авах шимтгэлийн хэмжээг тогтоох журмын төслийг боловсрууллаа.

2.4. Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх бололцоог өргөтгөж, санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр банкны байгууллага оролцсон санхүүгийн нэгдлүүд нэмэгдэх хандлагатай байгаагаас тухайн санхүүгийн нэгдлүүдэд нэгдсэн байдлаар хяналт шалгалт хийх тогтолцоог бүрдүүлэх шаардлага үүссэн. Мөн УИХ-аас 2010 оны эхэнд баталсан Банкны тухай хуульд банк, түүний хараат болон охин компани Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авч, хөрөнгийн зах зээлд оролцохоор болсон.

Иймд Монголбанкнаас нэгдсэн хяналт шалгалтын журмын төслийг боловсруулж, хянан шалгагч нар болон Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох ажилтнуудад танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд цаашид энэ үеэр гарсан саналуудад үндэслэн журмын төслийг Банкны тухай хууль болон бусад холбогдох журам, заавруудтай уялдуулж Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран илүү боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хороон дээр байгуулагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Монголбанкнаас төлөөлөл орж ажиллаж байна.

2.5. Гадаадын банкны салбар, нэгжийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гадаадын банк, банкны нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан гадаадын банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний хязгаарлалт болон банкны нэгжийн үйл ажиллагаа, тэдгээрийн ирээдүйн чиг хандлагын талаар хийсэн хэд хэдэн судалгаанд үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-80 дугаар тушаалаар “Банкны зөвшөөрлийн журам”-ыг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-99 дүгээр тушаалаар “Банкны нэгжийн журам”-ыг тус тус баталж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Эдгээр журмуудад гадаадын банк нь Монгол улсад банкны үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн тохиолдолд эхлээд төлөөлөгчийн газар хэлбэрээр нэгээс доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулсан байх, энэхүү шаардлагыг хангасан тохиолдолд зөвхөн охин компани хэлбэрээр банкны үйл ажиллагааг эрхлэх хүсэлт тавих тухай болон бусад холбогдох зохицуулалтыг дэлгэрэнгүй тусгасан.

Гурав. Төв банкны бусад үйл ажиллагааны хүрээнд:

3.1. Төлбөрийн карт, интернет, мобайл зэрэг бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлж, төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллана.

1. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлгэдэн нэрлэсэн Үндэсний брэнд “₮ карт”-ыг нэвтрүүлэх ажлыг Монголбанкнаас зохион байгуулж, дараах ажлууд хийгээд байна. Үүнд:

- “₮ карт” гаргах, хүлээн авах зөвшөөрлийг картын үйл ажиллагаа эрхлэгч 9 банк авснаас одоогийн байдлаар ХХБ нийт 41.6 мянга, ХААН банк 13.0 мянга, Хадгаламж банк 22.2 мянга, Голomt банк 13.5 мянган карт эзэмшигчтэй болсон байна.
- 2012 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хэвлэлийн бага хурал хийж, “₮ карт”-ыг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг амжилттай зохион байгуулсан бөгөөд “₮ карт”-ыг дэлгэрүүлэх зорилгоор банкуудтай хамтран ажиллаж байна.
- Засгийн газраас хэрэгжүүлж буй хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг дэмжиж, хүүхдийн мөнгөний ₮ картын дизайныг гарган, иргэдэд хүртээл болгох бөгөөд тус ₮ картыг зөвхөн

хүүхдэд өөрт нь зориулж, хуримтлалтай ирээдүйг дэмжих агуулгыг билэгдэж байгаа юм. Үүний дагуу Монголбанкны “Бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоо”, “Төлбөрийн картын журам”-д холбогдох өөрчлөлтийг 2012 оны 12 дугаар сард оруулсан.

- Бэлэн бус төлбөр тооцоог сурталчлах ажлын хүрээнд Үндэсний брэнд картын лого бүхий стикер, ширээний жижиг пластик сурталчилгааны самбар болон хаалганд өлгөдөг самбарыг “Төгс чанар” ХХК –тай хийсэн гэрээний дагуу хэвлүүлж, банкуудад хүлээлцсэн акт үйлдэн хуваарилсан.
- “Юнайтед Пи Ар” ХХК-тай гэрээ байгуулан 10 нийтлэлийн эх бэлтгэж “Өдрийн сонинд” нийтлүүлж, ХААН, Худалдаа хөгжлийн банктэй хамтарсан ₮ картын талаарх нэвтрүүлгийг NTV, Eagle, Боловсрол сувгаар тус тус цацуулсан.

Цаашид Монголбанк “₮ карт” дээр тулгуурлан төрийн үйлчилгээг иргэдэд зардал чирэгдэл багатай хүргэх, гар утастай холбох зэрэг ажлыг хийхээр төлөвлөж байна.

2. Монголбанк төлбөрийн картын үйлчилгээг нэгдсэн нэг гарцтай болгох талаар Чайна юнион пэй (CUP) байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулаад байна. Энэ нь төлбөрийн картын үйлчилгээний шимтгэлийг бууруулах, банкуудын тус тусдаа төлдөг хураамжийн хэмжээг багасгах, төлбөрийн картаар өөрийн орондоо төдийгүй CUP-ийн гишүүн орнуудад төлбөр тооцоог саадгүй, хямд зардлаар гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх юм.

3. “Банксүлжээ” систем, бага дүнтэй болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд:

- ҮЦГТ-өөр нийт 779 тэрбум төгрөгийн дүнтэй 17 сая ширхэг картын гүйлгээ, 532.7 тэрбум төгрөгийн дүнтэй 6.3 сая ширхэг бага дүнтэй гүйлгээ хийгджээ.
- Банксүлжээ системээр 30 их наяд төгрөгийн дүнтэй 891.6 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ амжилттай боловсруулагдсан байна.

4. Төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор төлбөрийн системийн оролцогчийн нөөц төв, түүнд тавигдах техникийн зохистой шаардлагыг тодорхойлж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А-40 дүгээр тушаалаар батлуулж, системийн оролцогчдод хүргүүлсэн. Үүний дагуу тайланг төлбөрийн системийн оролцогч 17 байгууллагаас гаргуулан авч, зайнаас хяналт шалгалт хийж, шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээ авч байна.

5. Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлогыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооны 187/244/261 тушаалаар батлуулав.

3.2. Мөнгөний бодлогын зорилго, түүнд хүрэх арга замыг олон нийтэд ил тод, нээлттэй байлгаж, Төв банкны бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэн инфляцийн хүлээлтэд нөлөөлөх чадамжаа дээшлүүлнэ.

Монголбанк гаргасан бодлогын шийдвэр болон хэрэгжилтийг олон нийтэд ил тод тайлбарлах, мэдээллийн нээлттэй байдлыг хангах замаар бодлогод итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, инфляцийн хүлээлтийг удирдах чадамжийг сайжруулан ажиллалаа.

Монголбанкны хэвлэлийн хурлыг хуваарийн дагуу 2012 оны туршид зохион байгуулж, мөнгөний бодлогын хэрэгслүүдэд гарсан өөрчлөлтийг олон нийтэд мэдээллэв. Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл шинээр байгуулагдсанаар бий болох эерэг нөлөөлөл, ач

холбогдлын талаар хэвлэлийн хурал зарлан, олон нийтэд мэдээлэв. Мөн Үндэсний брэнд ₮ карт болон Юнион Пэй картын талаар цаг үеийн асуудлаар 2 удаа хэвлэлийн хурал зохион байгуулав.

Монголбанкны бодлогын шийдвэр гаргах хэвлэлийн хурлын протоколыг бүрэн эхээр нь цахим хуудаст байршуулах ажлыг эхлүүлэв. Үүний хүрээнд Үндэсний брэнд ₮-картыг танилцуулах болон 2012 оны 4 дүгээр сарын мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, 10 дугаар сарын Мөнгөний бодлогын зөвлөл байгуулсантай холбогдуулан зохион байгуулсан хэвлэлийн хурлын протоколуудыг бүрэн эхээр нь цахим хуудаст байршуулав.

Монголбанкны цахим хуудсаар дамжуулан цаг үеийн болон графикт 450 гаруй мэдээ мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав. Засгийн газар, Монголбанкнаас Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрийн талаарх тусгай цэсийг Монголбанкны цахим хуудаст шинээр үүсгэн, холбогдох мэдээллүүдийг давхардсан тоогоор 30 удаа байршуулсан. Монголбанкны зүгээс дэд хөтөлбөрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 80 удаа ярилцлага, тодруулга өгсөн болно.

Монголбанкны удирдлагаас их дээд сургуулиудын оюутнуудад лекц унших практикийг нэвтрүүлэх үүднээс МУИС-ийн оюутнуудад мөнгө, ханшийн бодлого, түүний хэрэгжилтийн талаар 8 удаагийн сургалтыг зохион байгуулав.

Сэтгүүлчид, санхүүгийн захад оролцогчдын санхүү, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс Парламентын сэтгүүлчдийн холбоотой хамтран III/16-нд “Ханш” сэдвээр, Санхүүгийн зах зээлийн холбоотой хамтран IV/19-нд “Төв банкны хараат бус байдал, мөнгөний бодлого” сэдвээр, X/2-нд “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл” сэдвээр, XII/18-нд Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран “Макро эдийн засгийн орчин ба Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлого”, “Банкны секторын хууль, эрх зүйн асуудлууд”, “Засгийн газрын үнэт цаасны дотоодын зах зээлийн арилжаа, ач холбогдол” сэдвүүдээр тус тус сэтгүүлчдийн сургалтыг зохион байгууллаа.

Хүүхэд, багачуудад зориулсан уламжлалт өдөрлөгийн хүрээнд IV/20-д Монголбанк Нийслэлийн 23-р сургууль дээр зочлон сурагчдад “Үнийн тогтвортой байдал бидний амьдралд яагаад чухал вэ?” сэдэвт хүүхэлдэйн киног номын хамт танилцуулсан.

Инфо хаяг болон Twitter, Facebook мэдээллийн сүлжээнд Монголбанкны хуудсыг нээж тухай бүр мэдээллээр ханган иргэдийн сонирхсон 530 гаруй асуултад хариулж мэдээлэл өгөв.

Мөнгөний статистикийн тоймыг цахим хуудас болон гэрээ бүхий 12 сониноор дамжуулан улирал тутам нийтэд мэдээлснээс гадна “Монголбанкны судалгааны ажил” тохимол №6, “Монголбанкны 2011 оны тайлан”-г англи, монгол хэлнээ, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл” хэвлэмэл бүтээгдэхүүнийг хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгов.

3.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-ын шаардлагад нийцүүлэх арга хэмжээг Засгийн газартай хамтран авч хэрэгжүүлнэ.

Хууль эрх зүйн хүрээнд

ФАТФ-аас манай улсад Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд өөрчлөлт хийхээс гадна, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулинд

“мөнгө угаах”, “терроризмыг санхүүжүүлэх” гэмт хэргийн хамрах хүрээг өргөтгөх, дээрх гэмт хэргүүдээр хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татах, хөрөнгө хураах, битүүмжлэх ажлыг НҮБ-ын холбогдох конвенцид нийцүүлэхийг зөвлөсөн.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 15 тоот тушаалын дагуу Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг анх байгуулагдсан юм.

Дээрх ажлын хэсэг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн анхны төслийг бэлтгэж, түүнд 2011 оны 10 дугаар сард Дэлхийн банкны зөвлөхүүдийн саналыг авч тусгасан. Улмаар дээрх хуулийн төсөлд Засгийн гишүүдийн саналыг авахаар 2012 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Хууль зүй дотоод хэргийн яамнаас Засгийн газрын гишүүдэд албан тоот хүргүүлсэн.

Хуулийн төсөл Засгийн газрын гишүүдэд танилцуулагдаж байх хугацаанд 2012 оны УИХ-ын сонгууль болж, шинэ Засгийн газар байгуулагдсан тул дээрх хуулийн төслийг дахин боловсруулахаар болсон. Иймд, Хууль зүйн сайдын 2012 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/57 тоот тушаалаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.

Шинээр байгуулагдсан ажлын хэсэг тус төсөлд Олон улсын валютын сан, НҮБ-ын терроризмыг эсрэг хяналтын баг, Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хяналтын бүлгийн мэргэжилтнүүдээс ирүүлсэн саналуудаас тусгаж хуулийн төслийг шинээр боловсруулсан. Хуулийн төслийг Засгийн газрын гишүүд, яам, агентлагуудад танилцуулж, тэдгээрийн саналыг авахаар Хууль зүйн сайдын 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/1636 тоотын дагуу албан тоот хүргүүлээд байгаа бөгөөд УИХ-ын 2013 оны хаврын чуулганаар тус хуулийг батлуулахаар ажиллаж байна.

Монголбанк нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулинд орох нэмэлт өөрчлөлтийн талаар гаргаж байгаа ахиц дэвшлийг ФАТФ-г улирал бүр бичгээр болон амаар танилцуулан тайлагнаж байна.

Бүтэц зохион байгуулалтын хүрээнд

Санхүүгийн мэдээллийн алба /СМА/-ны одоо байгаа орон тоо /6 хүн/-г нэмэгдүүлэхийг шаардсаны дагуу 2012 оны 1 дүгээр сарын 17-ны Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар СМА-г дахин 3 орон тоогоор нэмж 9 орон тоотой болголоо. Нэмэгдсэн орон тоонд ажилтнуудыг шалгаруулж авсан.

ФАТФ-аас Санхүүгийн зохицуулах хорооны орон тоог нэмэгдүүлэхийг шаардсаны дагуу Санхүүгийн зохицуулах хороо 2012 онд өөрийн бүтцэд ажиллах орон тоог нэмэгдүүлэх тогтоол гаргаж, 2013 оны төсөвтөө дээрх нэмэгдэл орон тоог санхүүжүүлэх хөрөнгийг тусгасан байна.

**ГОЛ НЭРИЙН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ
ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ
(2013 оны 1 дүгээр улирлын байдлаар)**

Монголбанкнаас Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталсан билээ. Энэхүү санамж бичгийн хүрээнд “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр (FPS)”, “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр (SIFS)”, “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр (TLF)”, “Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр (HPS)”-ийг тус тус хэрэгжүүлж байна.

**1. “ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ
ТОГТВОРЖУУЛАХ (FPS) ДЭД ХӨТӨЛБӨР”**

**[248.0 тэрбум төгрөгийн зээлийн шугамаас 139.5 тэрбум төгрөгийг ашигласан.
Ашиглалт 56%]**

Махны үнийг тогтворжуулах зорилгоор Монголбанк 87.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн шугамыг нээж, банкуудаар дамжуулан нөөцийн менежерүүдэд олголоо. Ингэснээр нөөцийн менежер зоорин дахь махны нөөцөө барьцаалан банкнаас хөнгөлөлттэй зээл авч, нөөцийн махыг хангалттай хэмжээгээр, бодитой бүрдүүлээд байна. Үүний үр дүнд махны нийлүүлэлтийн тогтвортой байдал хангагдан, махны жижиглэнгийн худалдааны үнэ тогтвортой байх нөхцөл бүрдсэн болно.

Нөөцийн менежерийн зооринд мах хүлээн авахад Мэргэжлийн хяналтын болон Онцгой байдлын газрууд давхар хяналт тавив.

Энэхүү дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 16,000 тонн махны нөөц бэлтгэхээс 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 10,896.3 тонн мах буюу нийт нөөцийн 68.1 хувийг бэлтгээд байна. Улаанбаатар хотод 8,855.1 тонн, Дархан хотод 1,025.1 тонн, Эрдэнэт хотод 1,016.1 тонн махны нөөц бүрдүүлсэн байна. Цагаан сарын баярын үеэр үнийн өсөлтөөр сэргийлэх зорилгоор 425.4 тонн нөөцийн махыг борлуулжээ. Нөөцийн махны борлуулалт 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 946 тоннд хүрчээ. Нөөцийн махыг Улаанбаатар хотод 377 жижиглэн борлуулах дэлгүүр, 6 хүнсний зах дээр боруулж байна. Дархан хотод 2 хүнсний зах, Эрдэнэт хотод 3 хүнсний захаар нөөцийн махыг борлуулж байгаа юм.

Үнэ тогтворжуулах хөтөлбөргүй үед буюу 2011 оны 11 дүгээр сараас 2012 оны 4 дүгээр сарыг хүртэлх 5 сарын хугацаанд махны үнэ дунджаар 66 хувиар өсч байсан бол хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн хугацаанд буюу 2012 оны 11 дүгээр сараас 2013 оны 4 дүгээр сарыг хүртэлх хугацаанд үнийн өсөлт 24 хувь болж огцом буурчээ. Үүнээс үзэхэд энэхүү дэд хөтөлбөр нь махны үнийн өсөлтийг сааруулж, тогтвортой байлгах үндсэн зорилтыг хангаж байна.

Гурилын үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гурилын үйлдвэрүүд үр тарианы нөөцөө барьцаалж эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авах, агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлж, хүнсний бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоо бүрдэх юм. “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас нийтдээ 34 гурилын үйлдвэрийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна.

2013 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар Монголбанкнаас оролцогч банкуудад нээсэн зээлийн шугамыг ашиглан нийт 20 гурилын үйлдвэр 39.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэр авч, гурилын үйлдвэрлэлээ саадгүй явуулж байна. Энэ нь хөтөлбөрийн батлагдсан санхүүжилтийн 65 хувь юм. Эдгээр 20 үйлдвэр нь тайлант хугацааны байдлаар нийт 33.4 мянган тонн буудайн нөөцтэй байна. Бусад 14 үйлдвэрийн зээл авахтай холбоотой материалыг харилцагч банкууд нь судалж байна.

Гурилын үйлдвэрүүдийн улаан буудай худалдан авах зардлыг хөнгөлөлттэй нөхцлөөр санхүүжүүлэх замаар гурилын нөөцийг бүрдүүлснээр нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдлээ. Гурилын жижиглэнгийн худалдааны үнэ тогтвортой байна.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор цаашид авах шаардлагатай арга хэмжээ:

- Тоон мэдээллийг сайжруулах, ялангуяа Улаанбаатар хотод нийлүүлэгдэж байгаа махны нийлүүлэлтийн хэмжээг бодитой тооцоолох, үүнтэй уялдуулан нөөцийн махны борлуулалтын хэмжээг оновчтой тогтоох;
- Шаардлагатай тохиолдолд махны нөөцийг нэмж бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;
- Нөөцийн махны борлуулалтын суваг, зохион байгуулалтыг сайжруулах;
- Махны үнийн өөрчлөлтийн богино хугацааны таамаглал хийж, нөөцийн махыг хэрэгцээт цэг дээр шуурхай нийлүүлэх ажлыг зохион байгуулах;
- Гурилын үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, чанар болон жижиглэн худалдааны үнийн хяналтыг боловсронгуй болгох;
- “Хүнсний бүтээгдэхүүний зoorь, агуулахыг нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

2. “ШАТАХУУНЫ ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДААНЫ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ (SIFS) ДЭД ХӨТӨЛБӨР”

[167.0 тэрбум төгрөгийн зээлийн шугамаас 105.3 тэрбум төгрөгийг ашигласан. Ашиглалт 62.1%]

Монголбанкнаас нефтийн бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдааг хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, хил дээрх өртгийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн Уул уурхайн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

Дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанк нь 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан 11 хэрэгжүүлэгч компанид **3.8%**-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай **105.3** тэрбум төгрөгийн санхүүжилт олгосны зэрэгцээ нийт **198.2** тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг **2-6** сарын дараа худалдах форвард хэлцлийг хийгээд байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниуд (i) жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнээ хямд зардлаар санхүүжүүлж, **зээлийн хүүгээс шалтгаалсан өртгөө бууруулах нөхцөл бүрдэж**, (ii) нефтийн төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой **валютын ханшийн эрсдлээ бууруулж чадсан** байна.

Хөтөлбөргүй үед буюу 2011 оны 9 дүгээр сараас 2012 оны 3 дугаар сарын хоорондох 7 сарын хугацаанд импортын түлш шатахууны хилийн үнэ 1 хувиар өссөн байхад дотоодын жижиглэнгийн түлш шатахууны дундаж үнэ 8 хувиар өсч байв. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хугацаанд буюу 2012 оны 9 дүгээр сараас 2013 оны 3 дугаар сарын хоорондох хугацаанд

импортын хилийн үнэ 11 хувиар өссөн байхад дотоодын жижиглэнгийн худалдааны үнэ 6 хувиар л өссөн юм. Үүнээс дүгнэхэд гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлтийн эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг зөөллөх, жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах хөтөлбөрийн зорилт хангагдаж байна.

2013 оны 2 дугаар сарын 14-ний өдөр оролцогч талууд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хамтарсан үнэлгээ хийж, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон.

Хийгдсэн ажил, хүрсэн үр дүн:

- Дэд хөтөлбөрийн хүрээнд 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт **105.3** тэрбум төгрөгийн зээлийг жилийн 3.8% хүүтэйгээр хэрэгжүүлэгч компаниудад олгож, нийт **198.2** тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг **2-6** сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэснээр шатахуун импортлогч компаниудын валютын ханшийн эрсдлийг бууруулсан.
- Засгийн газрын 126 дугаар тогтоолын үр дүнд компаниудын газрын тосны бүтээгдэхүүний нөөц 2012 оны эцсийн байдлаар хөтөлбөрийг эхлүүлсэн 2012.10.23-ны өдөртэй харьцуулахад 2 дахин нэмэгдэж, нийлүүлэлтийн тасралтгүй байдал хангагдсан.
- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор импортолсон автобензин, дизелийн түлшинд татвар ногдуулах эрхзүйн орчинг бүрдүүлсэн.
- “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” болон “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.
- Шатахуун борлуулагч аж ахуйн нэгжүүд болон төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа сайжирсан.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх ажлын хүрээнд гадаад худалдан авалтыг эрчимжүүлснээр гадаадын хэд хэдэн компаниудтай хөнгөлөлттэй нөхцөл бүхий гэрээ байгуулж, нийтдээ 20 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон.
- Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан олон нийтийн зүгээс шатахууны үнэ, нөөц, боловсруулах үйлдвэр зэрэг асуудалд тавих хяналт эрс сайжирсан.

Тулгамдаж буй асуудал:

Дэд хөтөлбөр нь дээр дурдсан үр дүнд хүрсэн хэдий ч хөтөлбөрийн зарим ажлууд тайлант хугацаанд бүрэн биелээгүй байгаа нь дараах арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаагаар холбоотой байна.

- Шатахууны жижиглэнгийн худалдааны мэдээг гаргах журам, зааврыг батлан мөрдүүлэх, зээлийн шугамын дүнг шинэчлэн тооцох,
- Шатахууны биет нөөцийг хадгалах улсын эзэмшлийн агуулах барих, нөөцийг биетээр бүрдүүлэх, хяналтын механизм бий болгох,
- Шатахууны нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх,

Цаашид авах арга хэмжээ:

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулахын зорилгоор дараах арга хэмжээ авах шаардлагатай гэж үзэж байна:

- Замын-Үүд дэх шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж, агуулах сав барих ажлыг эрчимжүүлэх,
- БНСУ, БНХАУ-аас оруулж ирэх шатахууны нийлүүлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх,
- Гадаад үнийн өсөлтийг шатахууны бөөний үнэд бүрэн шингээх асуудлыг шийдвэрлэх,
- Хэрэгжилтийн шатандаа байгаа ажлуудыг эрчимжүүлэх: Дэд хөтөлбөрт заасан жижиглэнгийн худалдааны журмыг батлан мөрдүүлэх, жижиглэнгийн зах зээлийн статистик, тоо мэдээллийг олон нийтэд ил тод болгох, улсын нөөцийг хадгалах сав барих санхүүжилтийг шийдвэрлэх, улсын нөөцийг бүрдүүлж эхлэх зэрэг ажлуудыг эрчимжүүлж, 2013 оны 2 дугаар улиралд багтаан хэрэгжүүлж дуусгах,
- Дэд хөтөлбөрийн зорилтыг олон нийтэд бүрэн таниулж, дотоодын зах зээлд жижиглэнгийн үнэ хэрхэн бүрдэж байгааг ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулах,

3. “ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ ИМПОРТЫН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТГИЙГ БУУРУУЛАХ (TLF) ДЭД ХӨТӨЛБӨР”

[303.0 тэрбум төгрөгийн зээлийн шугамаас 22.0 тэрбум төгрөгийг ашигласан. Ашиглалт 7.3%]

Гадаад худалдааны тээвэр, ложистикийн дэд бүтцийг сайжруулах замаар өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор TLF дэд хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн Зам, тээврийн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

Дэд хөтөлбөрт тусгасан үндсэн 5 зорилтын хэрэгжилтийг 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дүгнэвэл дараах байдалтай байна:

Зорилт 1: Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлэх (Замын Үүд – Улаанбаатар чиглэл)

Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний Замын-Үүдээс Улаанбаатар чиглэлийн тээвэрлэлт, ачаа эргэлтийг хурдасгахаар тусгайлсан галт тэргийг 2012.10.29-ний 09:00 цагаас эхлэн тогтсон хуваарийн дагуу аялуулж эхэлсэн бөгөөд 2013 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 304 галт тэрэг, 17,651 вагоноор нийт 948 мянган тонн ачааг тээвэрлээд байна.

Түүнчлэн, авто зам, төмөр замаар орж ирсэн ачааг сааталгүй сэлгэн ачих, ачилтын бригадын зохион байгуулалтыг сайжруулах, хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх, Улаанбаатар хотод ирсэн ачааг гар утасны мессежээр хэрэглэгчдэд мэдэгдэх, “хаалганаас хаалганд” ачаа хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх, ачаалалтай өдрүүдэд нэмэлт галт тэргийг аялуулах зэрэг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлээд байна.

Монголын уламжлалт Цагаан сарын баярыг угтаж өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах, тээвэрлэлтийг тасралтгүй бөгөөд шуурхай зохион байгуулах арга хэмжээ авч ажилласан.

Зорилт 2: Ачаа тээвэрлэлтийн өртгийг бууруулах

Монголбанк нь хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн шатахуун худалдан авах эргэлтийн хөрөнгөд зориулан 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдөр жилийн **3.8%**-ийн хүүтэй, **3** жилийн хугацаатай **22.0** тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Тус нийгэмлэг нь дээрх эх үүсвэрийг ашигласнаар шатахуун худалдан авалтын эргэлтийн хөрөнгийг бүрдүүлж, улмаар төмөр замын тээвэрлэлтийн өртгийг бууруулах нөхцлийг бүрдүүлэх боломжтой болж байна.

Зорилт 3: Тяньжин-Замын-Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хөнгөвчилөх

Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын Монголын талын ажлын хэсгийн хурал 2013 оны 2 дугаар сард 2 удаа хуралдаж, дээрх асуудалд холбогдох саналыг комисст хүргүүлсэн байна.

Зам, тээврийн сайдын 2013 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 48 дугаар тушаалаар Монгол-Хятадын төмөр замын тээврийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх асуудлыг судлах, холбогдох арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулжээ. Ажлын хэсэг нь БНХАУ-ын төмөр замын тээвэр хариуцсан холбогдох албан тушаалтнуудтай Тяньжин-Замын-Үүд чиглэлийн тээврийг хөнгөвчлөх болон төмөр замын бусад асуудлуудаар уулзаж, БНХАУ-ын талд санал тавихаар төлөвлөж байна.

Зорилт 4: Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх

Дэд хөтөлбөрт 1000 ачааны вагон, 20 зүтгүүрийн худалдан авалтад нийт 231 хүртэл тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан. Харин "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Ерөнхий хорооны 2013 оны 1-р сарын 29-ны өдрийн хурлаар хөдлөх бүрэлдэхүүний паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 400 ачааны хагас вагон, 60 ачааны битүү вагон, 3 гол замын зүтгүүр, 3 сэлгээний зүтгүүрийг худалдан авахад нийт 70 тэрбум төгрөгийн зээлийн асуудлыг дэмжсэн байна. УБТЗ ХНН-ийн 2013 оны үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөө ачаа тээврийн тарифын өөрчлөлтөөс шалтгаалан батлагдаагүй байгаа тул энэхүү зээлийн асуудал хүлээгдэж байна.

Зорилт 5: Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх

Дэд хөтөлбөрт Замын-Үүд боомтын төмөр зам, авто замын ачааны терминалыг өргөтгөх, Улаанбаатар хот дахь ачааны терминалын ачаа боловсруулах чадварыг нэмэгдүүлэхэд нийт 50 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан. Санхүүжилт авах асуудлаар ЗТЯ, УБТЗ ХНН-ийн зүгээс тодорхой шийдвэр гаргаагүй байна.

ЗТЯ нь удирдлага зохион байгуулалтын шинж чанартай дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна:

- Замын-Үүдийн ачааны терминалын ачаа боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд технологийн горимын мөрдөлтийг сайжруулах, вагоны ачилт буулгалтын ажиллагааг хурдасгаж, вагон эргэлтийн хугацааг цемент тээвэрт 2.3 хоног, бусад ачаанд 3.5 хоног болгон бууруулах замаар хурдасгасан.
- Барилгын материалын тээвэр нэмэгдэж байгаатай уялдан Замын-Үүдийн ачааны терминалын хүчин чадлыг харгалзан Эрээн өртөөнд цементийн шилжүүлэн ачилт хийх талаар 2013 оны 03 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд Хөх хотын төмөр замын удирдлага, Эрээн өртөөний даргатай очиж уулзаж, асуудлыг шийдвэрлэсэн.

**4. “БАРИЛГЫН САЛБАРЫГ ДЭМЖИХ, ОРОН СУУЦНЫ ҮНИЙГ
ТОГТВОРЖУУЛАХ (HPS) ДЭД ХӨТӨЛБӨР”**

Энэхүү хөтөлбөрийг Монголбанкнаас Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)-тай хамтран 2013 оны 1 дүгээр сард баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд одоогоор санхүүжилт хийгдээгүй байгаа бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Тухайлбал, Монголбанкнаас “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх” бодлогын санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлсний зэрэгцээ энэхүү дэд хөтөлбөрийн хүрээнд банкуудтай байгуулах гэрээний төслийг боловсруулж дуусаад байна.